БНМАУ-ЫН НИЙТИЙН АЖ АХУЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯАМНЫ САЙД, УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1990 оны 4 сарын 3 өдөр    Дугаар А-53/б/41    Улаанбаатар хот

ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ХАРЬЯАЛАЛ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

ТУШААХ нь:

1. Улс ардын аж ахуйн удирдлагын бүтцэд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан яамны шууд харьяа                Өнгөт зургийн төвийг Улаанбаатар хотын Ахуйн үйлчилгээний удирдах газарт, Бүртгэлийн машинт станцыг Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газарт тус тус харьяалуулсугай.

2. Монголын үйлдвэр-үйлчилгээний ажилд туслах нийгэмлэг, түүний бүрэлдэхүүн байгууллагуудын албан ажлын хэрэгцээнд зориулж хавсралтад заасан автомашинуудыг Авто тээврийн баазаас Туршилт тохируулгын ангид шилжүүлсүгэй.

3. Яамны шууд харьяа Авто тээврийн бааз, Лифтийн засвар үйлчилгээний контор,                Захиалагчийн товчоог Улаанбаатар хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд шилжүүлсүгэй.

НИЙТИЙН АЖ АХУЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯАМНЫ САЙД    Т.ДЭМЧИГДОРЖ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА    Л.ЭНЭБИШ

Нийтийн аж ахуй, үйлчилгээний яамны сайд, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргын хамтарсан х тушаалын хавсралт

# АВТО ТЭЭВРИЙН БААЗААС ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Автомашины марк | Автомашины тоо хэмжээ /ш-ээр/ | улсын дугаар |
|---|---|---|
| Газ-24 | I | УБН - 05 - 06 |
| Газ-24 | I | УБ - 37 - 76 |
| Газ-53 | I | УБ - 98 - 00 |
| Ролик | I | УБ - 95 - 68 |
| Газ-53 | I | УБ - 98 - 0I |
| Суудлын шкода /комби/ | I | УБ - 96 - 22 |
| | 6 | |